

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2009 он 12 дугаар
сарын 23 -ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилерийн үйл ажиллагаа явуулж буй нэр бүхий 11 компанид хийсэн шалгалтын нэгдсэн тайланг Үнэт цаасны газрын дарга Э.Ганбат сонсгож танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Шалгалтын нэгдсэн тайлантай танилцаад дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд үүрэг болгохоор шийдвэрлэв:

1) Эдийн засгийн хямралт байдлыг даван туулахад брокер, дилерийн компаниудын үйл ажиллагааг хэрхэн дэмжих талаар саналаа 2010 оны 1 дүгээр сард багтаан Хорооны хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

2) Хорооны мэдээллийн санд компаниудаас мэдээлэл ирүүлэх ажиллагааг тогтмолжуулах үүднээс зайнаас тавих хяналтыг сайжруулан холбогдох мэдээллийг Санхүүгийн зохицуулах хорооны вэб сайт дээр байршуулан олон нийтэд тогтмол мэдээлж байх;

3) Шалгалтаар илэрсэн зөрчил түүний дагуу авсан арга хэмжээтэй холбогдон гарах шийдвэрийн талаар Хорооны вэб хуудсанд байршуулан нийтэд мэдээлэх;

4) Орон нутагт үйлчилгээ үзүүлдэг компаниудын хувьд Хорооны төлөөлөгчөөр дамжуулан орон нутаг дахь үйлчилгээний хүртээмж, чанарт хяналт тавьж ажиллах.

2. Энэхүү өгсөн үүргийн хэрэгжилтийн талаар Хороонд танилцуулахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-д даалгав.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН